



САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ТОГТООЛ

2022 оны 08 сарын 09 өдөр

Дугаар 99

Улаанбаатар хот

“Булган-Ундрага” ХК-ийн Санхүүгийн зохицуулах
хорооны бүртгэлд өөрчлөлт оруулах тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.1, 6.2.2, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 63 дугаар зүйлийн 63.1.1, Санхүүгийн зохицуулах хорооны 2021 оны 225 дугаар тогтоолоор баталсан “Үнэт цаасны бүртгэлийн журам”-ын 9.5.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Булган-Ундрага” ХК-ийн оноосон нэрийг “Крипто үндэстэн” ХК болгон Санхүүгийн зохицуулах хорооны бүртгэлд өөрчлөлт оруулахыг Үнэт цаасны газар /Б.Дөлгөөн/, үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн бүртгэлд өөрчлөлт оруулахыг “Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв” ХХК /Ш.Лхагва/-д тус тус үүрэг болгосугай.

2. Компанийн оноосон нэрийг өөрчилсөнтэй холбогдуулан дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг “Крипто үндэстэн” ХК /Г.Мягмаржав/-д үүрэг болгосугай:

1/ Компанийн оноосон нэрийн өөрчлөлт, шинэчилсэн дүрмийг холбогдох журмын дагуу Улсын бүртгэлийн ерөнхий газарт бүртгүүлж, хувийг Санхүүгийн зохицуулах хороонд ажлын 15 хоногийн дотор ирүүлэх;

2/ Компанийн оноосон нэр өөрчлөгдсөн талаарх мэдээллийг хөрөнгө оруулагч, хувьцаа эзэмшигчдэд хүргэх.

3. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж, олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба /Т.Жамбаажамц/-нд даалгасугай.

ДАРГА  Д.БАЯРСАЙХАН

